

## ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

*Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл*

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенц нь энхийн зорилгоор ашиглах цөмийн материалыг олон улсын хэмжээнд аюулгүй тээвэрлэх, биечлэн хамгаалахад, конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт нь энхийн зорилгоор ашиглаж байгаа цөмийн байгууламж, цөмийн материалын үр дүнтэй биечлэн хамгаалах тогтолцоог дэлхий дахинд бий болгон хэвшүүлэх, цөмийн материал болон байгууламжийн эсрэг гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, оролцогч талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилготой.

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенц нь 1987 оны 02 дугаар сарын 08-ны өдөр хүчин төгөлдөр болсон ба манай улс 1986 онд нэгдэн орж, соёрхон баталсан.

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцод 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 164 улс нэгдэн орж, 44 улс гарын үсэг зурсан. Тус конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт нь 2016 оны 05 дугаар сарын 08-ны өдөр хүчин төгөлдөр болсон ба 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 137 улс нэгдэн орсон байна.

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенц нь зөвхөн олон улсын тээвэрлэлтийн үеийн биечлэн хамгаалах арга хэмжээнд хамаарч байсан бол конвенцод орсон 2005 оны нэмэлт, өөрчлөлт нь цөмийн байгууламж, түүнчлэн дотоодын хэрэглээ, хадгалалт, тээвэрлэлтэд байгаа цөмийн материалд хамаарч байна. Мөн конвенцын үйлчлэлд хамаарах гэмт хэрэгт цөмийн материалыг хууль бусаар нэвтрүүлэх, цөмийн байгууламжид хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулах зэрэг асуудлууд нэмэгдэж, хорлон сүйтгэх ажиллагааны талаарх мэдээлэл солилцох, туслалцаа үзүүлэх өргөтгөсөн хамтын ажиллагааны зохицуулалтууд нэмэгдсэн.

Олон Улсын Атомын Энергийн Агентлаг (“ОУАЭА”) нь Цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх “Баталгааны хэлэлцээр” ба Нэмэлт протоколыг хэрэгжүүлж буй улс орнуудын бүх цөмийн материал энхийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа эсэх талаар өргөн хэмжээний албан ёсны дүгнэлтийг гаргадаг.

Монгол Улсын Их хурлын 2024 оны 8 дугаар сарын 10-ны өдөр баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.3.7-д “Ураны нөөцийг түшиглэн атомын цахилгаан станц барих бодлого хэрэгжүүлж суурь судалгааг хийнэ” гэж тусгасан бөгөөд улмаар ОУАЭА-аас гаргасан цөмийн эрчим хүчний эх үүсвэр барьж байгуулахаар төлөвлөж буй 27 улс, орнуудын жагсаалтад Монгол Улс орсон байдаг.

2024 оны 10 дугаар сарын 01-ний өдөр ОУАЭА-аас Монгол Улсын Цөмийн энергийн комисст ирүүлсэн албан бичигт Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протокол 2005 онд шинэчлэгдсэнээс хойш өнөөг хүртэл Монгол Улс нэгдэн орох арга хэмжээг аваагүйгээс үүдэн цөмийн технологийг энхийн зорилгоор ашиглаж байгаа баталгааны албан ёсны дүгнэлтийг ОУАЭА-аас гаргах боломжгүй болох тухай үр дагавар үүсэх талаар мэдэгдсэн.

Хэрэв 2024 оны дотор манай улс тус протоколд нэгдэн орох арга хэмжээг авахгүй бол эдийн засаг, эрүүл мэнд, аж үйлдвэр, хөдөө, аж ахуй, байгаль орчин, цацрагийн аюулгүй ажиллагааны чиглэлээр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүд цаашид хэрэгжих боломжгүй болох нөхцөл байдал үүсээд байна.

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 06 дугаар сарын 19-ны өдөр баталсан “Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” 60 дугаар тогтоолд Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орохыг Засгийн газарт даалгасан ба тус тогтоолыг хэрэгжилтийг хангах хүрээнд Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг Улсын Их Хурлаар соёрхон батлуулах талаар хэлэлцэн дэмжиж, Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой зөвшилцөхөөр шийдвэрлэсэн.

Улмаар Засгийн газраас тус конвенцыг соёрхон батлах тухай хуулийн төслийг 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр Улсын Их Хуралд зөвшилцөхөөр хүргүүлсэн бөгөөд Монгол Улсын Их Хурлын Аюулгүй байдал, гадаад бодлогын Байнгын хороо 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн хуралдаанаар конвенцод нэгдэн орох асуудлыг хэлэлцээд дэмжсэн санал, дүгнэлт гарсан.

2024 оны Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дараа Монгол Улсын Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбоотойгоор хуулийн төслийн үзэл баримтлалыг шинэчлэн батлуулж, Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 79.1-д заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу өргөн мэдүүлж байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

*Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл*

Монгол Улсын Их Хурлын 2015 оны 06 дугаар сарын 19-ны өдөр баталсан “Монгол Улсын цөмийн зэвсгээс ангид байх статусыг шинэ түвшинд гаргах тухай” 60 дугаар тогтоолын 3 дахь хэсэгт “Цөмийн аюулгүй байдлын тухай 1994 оны конвенц, Ашигласан түлшний болон цацраг идэвхт хаягдлын менежментийн аюулгүй ажиллагааны тухай 1997 оны конвенц, **Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцийн 2005 оны нэмэлт, өөрчлөлт** болон Бага хэмжээний цөмийн материалын шинэчилсэн протоколд тус тус нэгдэн орох” арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.

Иймд, Монгол Улсын Улсын Их Хурлын 2015 оны 60 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор энэхүү хуулийн төслийг боловсруулав.

### **1. Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл боловсруулах болсон хэрэгцээ, шаардлага**

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцод манай улс 1986 онд нэгдэн орсон.

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал анх 1999 онд сөхөгдсөн бөгөөд 2001 онд Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк хотноо болсон террорист халдлагын дараа нэмэлт, өөрчлөлт оруулах асуудал улам эрчимжсэн. Энэхүү террорист халдлагад цөмийн материал ашиглаагүй боловч ийм төрлийн аюул заналхийллээс урьдчилан сэргийлэх, улс орон бүр өөрийн цөмийн материал, цөмийн байгууламжийг биечлэн хамгаалах дэглэмийг бэхжүүлэх зорилгоор 2005 онд Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцод нэгдэн орсон улс орнууд Бүгд Найрамдах Австри Улсын Вена хотноо хуралдсан. Энэхүү бага хуралд 89 улсын төлөөлөгч оролцож, тухайн конвенцод нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэр гаргасан.

Улмаар Олон Улсын Атомын Энергийн Агентлаг (“ОУАЭА”) нь энхийн зорилгоор ашиглаж буй цөмийн байгууламж, цөмийн материалыг үр дүнтэй биечлэн хамгаалах дэглэмийг дэлхий дахинд бий болгож хэвшүүлэх, цөмийн материал болон байгууламжийн эсрэг гэмт хэрэг үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах, оролцогч улсуудын хамтын ажиллагааг бэхжүүлэхийн тулд энэхүү конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орохыг гишүүн орнуудад уриалсан.

Энэхүү конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орсноор манай улс одоогийн байдлаар их хэмжээний өндөр цацраг идэвхтэй цөмийн материал эсхүл цөмийн байгууламж байхгүй хэдий ч өөрийн орны цөмийн материал, цөмийн байгууламжийг биечлэн хамгаалах шаардлагыг үндэслэн олон улсын стандартад нийцсэн биечлэн хамгаалах дэглэмийг бий болгох боломжтой бөгөөд ингэснээр 1986 онд нэгдэн орсон Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцоор хүлээсэн үүргээ улам бэхжүүлэх ач холбогдолтой юм.

## **2. Дэлхийн улс орнуудын конвенцод нэгдэн орсон байдал**

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцод 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 164 улс нэгдэн орж, 44 улс гарын үсэг зурсан байна. Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлт нь 2016 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс хүчин төгөлдөр болсон ба 2024 оны 09 дүгээр сарын байдлаар 137 улс нэгдэн орсон байна.

## **3. Конвенцын зорилго, зохицуулах зүйл, хамрах хүрээ**

Конвенц нь зохицуулах харилцаа, зорилго, хамрах хүрээ, хүлээх үүрэг зэргийг тусгасан 23 зүйл, 2 хавсралт (*I хавсралт - II Хавсралтад ангилсан цөмийн материалыг олон улсын тээвэрлэлтийн үед биечлэн хамгаалах түвшин, II хавсралт - Цөмийн материалын ангилал*)-аас бүрдэнэ.

2005 оны нэмэлт, өөрчлөлтөөр Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын нэр, удиртгал хэсэг, 1, 2, 5, 6, 7, 11, 13, 14, 16 дугаар зүйл болон II дугаар хавсралтын b, e тайлбаруудад нэмэлт, өөрчлөлт орж, олон улсын тээвэрлэлтээс гадна, дотоодод ашиглаж, хадгалж, тээвэрлэж буй цөмийн материал болон цөмийн байгууламжийг биечлэн хамгаалах, мөн хулгайлагдсан, хууль бусаар хил нэвтрүүлсэн цөмийн материал, түүнд холбогдох гэмт хэрэг, хорлон сүйтгэх үйл ажиллагаатай тэмцэх зэрэгт олон улсын хамтын ажиллагааны хамрах хүрээг өргөжүүлсэн. Үүнд:

Нэмэлт, өөрчлөлтийн дагуу конвенцын нэр “Цөмийн байгууламж болон цөмийн материалыг биечлэн хамгаалах конвенц” болж өөрчлөгдсөн.

Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай 1980 оны конвенцын 1 дүгээр зүйл буюу зорилгод зөвхөн “цөмийн материал”, “уран-235 буюу уран-233 изотопоор баяжуулсан уран”, “цөмийн материалын олон улсын тээвэрлэлт” гэсэн нэр томъёонуудыг тодорхойлсон байдаг. 2005 оны нэмэлт, өөрчлөлтөөр эдгээр нэр томъёо бүхий заалтуудад “цөмийн байгууламж”, “хорлон сүйтгэх ажиллагаа” гэсэн нэр томъёо бүхий заалтууд болон 1А дугаар зүйлийг нэмснээр, зорилгыг “дэлхий дахинд энхийн зорилгоор ашиглаж буй цөмийн байгууламж болон цөмийн материалын үр дүнтэй биет хамгаалалтыг бий болгож хэвшүүлэх; энэхүү цөмийн материал болон байгууламжийн эсрэг гэмт хэрэг үйлдэгдэхээс дэлхий нийтээр урьдчилан сэргийлэхэд; түүнтэй тэмцэх чиглэлээр Талуудын хамтын ажиллагааг дэмжихэд оршино” хэмээн дэлгэрүүлж тодорхойлон тусгасан.

Нэмэлт, өөрчлөлтөөр конвенцын 2 дугаар зүйлийн 1-3 дахь хэсэгт өөрчлөлт орж, 4, 5, 2А дугаар хэсгүүд нэмэгдсэн. Ингэснээр 1980 оны конвенцын 2 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасны дагуу тус конвенцыг энх тайвны зорилгоор ашиглаж, хадгалж, тээвэрлэж байгаа цөмийн материалын хувьд хэрэглэхээр хамрах хүрээг тодорхойлсон байсныг нэмэлт, өөрчлөлтөөр энхийн зорилгоор ашиглаж, хадгалж, тээвэрлэж буй цөмийн материал болон энхийн зорилгоор зорилгоор ашиглаж буй цөмийн байгууламжийн хувьд хэрэглэнэ гэж өөрчилсөн. Мөн 2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Энэхүү конвенц цэргийн зориулалтаар ашигласан болон хуримтлуулсан цөмийн материал, эсхүл тухайн материалыг агуулсан цөмийн байгууламжийн хувьд хамаарахгүй” гэж нэмсэн.

Түүнчлэн шинээр нэмсэн 2А дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт цөмийн байгууламж болон цөмийн материалын зөв зохистой биечлэн хамгаалах дэглэмийг

бий болгох, хэрэгжүүлэх, хэвийн үйл ажиллагааг хангах арга хэмжээ болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ бүхий үүргийг тусгасан. 2А дугаар зүйлийн 3 дахь хэсэгт дээрх үүргийг хэрэгжүүлэхдээ зохих бололцооны хэрээр мөрдлөг болгох 12 үндсэн зарчмыг тусгасан. Эдгээр зарчимд А: Улс орны хүлээх үүрэг хариуцлага, В: Олон улсын тээвэрлэлтийн үед хүлээх үүрэг хариуцлага, С: Эрх зүйн болон хяналтын тогтолцоо, D: Эрх бүхий байгууллага, E: Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүрэг хариуцлага, F: Аюулгүй байдлын соёл, G: Аюул занал, H: Шаталсан арга зам, I: Нарийвчилсан хамгаалалт, J: Чанарын баталгаа, K: Гэнэтийн үед авах арга хэмжээний төлөвлөгөө, L: Нууцлал зэрэг асуудлууд тусгагдсан болно.

Нэмэлт, өөрчлөлтөөр 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт цөмийн материал болон байгууламжтай холбоотой хорлон сүйтгэх ажиллагаа явагдаж болзошгүй, бусад улс түүний цацрагийн нөлөөнд өртөх магадлалтай тохиолдолд тухайн Талд, шаардлагатай бол Олон улсын атомын энергийн агентлаг болон бусад холбогдох байгууллагуудад эсхүл тэдгээрээр дамжуулан мэдэгдэх, тусламж хүсэх, үзүүлэхтэй холбогдсон үүрэг, хариуцлагыг нэмсэн ба 4 дэх хэсэгт цөмийн материалыг олон улсад тээвэрлэх явцад түүнийг биечлэн хамгаалах тогтолцоог, 5 дахь бүлэгт дотооддоо хэрэглэж буй цөмийн материалын ашиглалт, хадгалалт, тээвэрлэлт болон цөмийн байгууламжийн биечлэн хамгаалалтын үндэсний тогтолцоог тус тус загварчилж боловсруулах, хэвийн үйл ажиллагааг хангах, сайжруулахтай холбоотой бусад Оролцогч Улстай шууд, эсхүл Олон улсын атомын энергийн агентлаг болон бусад олон улсын байгууллагуудаар дамжуулан зөвлөлдөж, хамтран ажиллах харилцааг тус тус нэмсэн.

6 дугаар зүйлд итгэмжлэн хүлээж авсан аливаа мэдээллийн нууцыг хадгалахын тулд өөрийн улсын хууль, тогтоомжийн дагуу зохих арга хэмжээг авах, өөр улсаас авсан нууц мэдээллийг зөвхөн тухайн оролцогч улсын зөвшөөрөлтэйгөөр гуравдагч талд дамжуулах зэрэг нууцтай холбоотой асуудлыг шинэчлэн өөрчилсөн байна.

7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт цөмийн материалтай холбоотой санаатайгаар үйлдэх гэмт хэрэгт 1980 оны конвенцод тусгагдсан заалтууд дээр нэмж эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр цөмийн материалыг зөөвөрлөх, илгээх, эсхүл тухайн улс руу оруулах, гаргах үйлдэл хийх зэрэг гэмт хэрэг болон цөмийн байгууламжтай холбоотой санаатайгаар үйлдэх, нэгдмэл зорилготой этгээдүүд бүлэглэн үйлдэх зэрэг гэмт хэргийг нэмж, тэдгээрийг Оролцогч Улс бүр үндэсний хууль тогтоомжийнхоо дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх гэмт хэрэгт тооцох арга хэмжээ авахтай холбоотой зохицуулалтыг тусгасан.

11 дүгээр зүйлийн дараа 11А, 11В дүгээр зүйлүүдийг нэмж, 7 дугаар бүлэгт өмнө байсан болон өөрчлөгдөж, шинээр нэмэгдсэн санаатайгаар үйлдэх гэмт хэргүүдэд хамаарах зохицуулалтууд нэмэгдсэн.

13А дугаар зүйлд “Энэхүү конвенцын аль ч заалт нь цөмийн байгууламж болон материалын биет хамгаалалтыг бэхжүүлэх зорилгоор авч хэрэгжүүлж буй энхийн зорилгоор ашиглах цөмийн технологийг дамжуулахад нөлөөлөхгүй” гэж нэмсэн. 14 дүгээр зүйлийн 3 дугаар хэсэг, 16 дугаар зүйл нь конвенцын хамрах хүрээнд цөмийн байгууламж нэмэгдсэнтэй холбоотой өөрчлөгдсөн эсхүл нэмэлтийн огноотой холбогдсон өөрчлөлтүүд болно.

1980 оны конвенц нь зөвхөн олон улсын тээвэрлэлтийн үеийн биечлэн хамгаалах арга хэмжээнд хамаарч байсан бол Конвенцод орсон нэмэлт, өөрчлөлт

нь цөмийн байгууламж, түүнчлэн дотоодын хэрэглээ, хадгалалт, тээвэрлэлтэд байгаа цөмийн материалд хамаарч байна. Мөн конвенцод хамаарах санаатай гэмт хэрэгт цөмийн материалыг хууль бусаар нэвтрүүлэх, цөмийн байгууламжид хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, хүрээлэн буй орчинд ноцтой хохирол учруулах зэрэг асуудлууд нэмэгдэж, хорлон сүйтгэх ажиллагааны талаарх мэдээлэл солилцох, туслалцаа үзүүлэх өргөтгөсөн хамтын ажиллагааны зохицуулалтууд нэмэгдсэн.

#### **4. Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа**

Хуулийн төсөл нь 1 зүйлтэй бөгөөд 1 дүгээр зүйлд Олон Улсын Атомын Энергийн Агентлагаас 1980 онд баталж, 1987 онд хүчин төгөлдөр болсон Цөмийн материалыг биечлэн хамгаалах тухай конвенцын 2005 оны нэмэлт, өөрчлөлтийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлах зохицуулалтыг тусгав.

#### **5. Хуулийн төсөл батлагдсанаар хүлээгдэж буй үр дүн**

Конвенцын нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орсон улс орон бүр цөмийн материалыг хулгайлах, хууль бусаар эзэмших, эдгээр учирч болох бодит аюул бий болсон тохиолдолд Олон улсын атомын энергийн агентлагт нэн даруй мэдэгдэх шаардлагатай. Энэхүү мэдээллийг үндэслэн тухайн улс өөрийн үндэсний аюулгүй байдлыг хангах, цөмийн террорист үйлдлээс урьдчилан сэргийлэх, бодит аюул тулгарсан тохиолдолд бусад орон, холбогдох олон улсын байгууллагуудаас дэмжлэг авах боломжтой.

Энэхүү нэмэлт, өөрчлөлтөд нэгдэн орсноор цөмийн материал болон цөмийн байгууламжийн биет хамгаалалтыг олон улсын түвшинд хүргэх, цөмийн терроризм, гэмт хэрэгтэй тэмцэх, олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлэх, эдгээр зорилтуудад нийцсэн үндэсний эрх зүйн орчныг бий болгоход дэмжлэг болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР